



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/578

Булган сум

Тусгай зөвшөөрлийн тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2.2.1, 8.1 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл"-ийг шинээр олгох цэгийн нэрсийг хавсралтаар баталж, 5 жилийн хугацаатай олгосугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-т заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга нар, Татварын газар (Д.Лхагвасүрэн), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т тус тус даалгасугай.

3.Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Г.Ганбаяр цагдаагийн дэд хурандаа), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Ц.Бүрэнтуяа), сумын Засаг дарга, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010623

08

дугаар сарын

Аймгийн Засаг даргын 2024 оны  
08 ны/ний өдрийн 1/378 дугаар  
захирамжийн хавсралт



**“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭРС**

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Булган	“Асгат могой” ХХК	Э.Аюурзана	Хүнсний дэлгүүр	“Өгөөмөр хайрхан”
2	Булган	“Пангаүм” ХХК	Д.Дэлгэрмаа	Хүнсний дэлгүүр	“Өсөн дэвжих”
3	Гурванбулаг	“Гомбо тайж” ХХК	Д.Намхайжанцан	Хүнсний дэлгүүр	“Хадагт хошуу”
4	Гурванбулаг	“Гурванбулаг Их тогоо” ХХК	Ц.Наранцэцэг	Хүнсний дэлгүүр	“Билгүүн саран”
5	Дашинчилэн	“Ягаахан туулайн зүрх” ХХК	Б.Мөнхтуяа	Хүнсний дэлгүүр	“Family”
6	Хишиг-Өндөр	“Хавтгайн бэл” ХХК	Ө.Чинбат	Хүнсний дэлгүүр	“Хөшөөт гол”
	Нийт- 6				